



УЛААНБААТАР  
ЦАХИЛГААН ТҮГЭЭХ СҮЛЖЭЭ  
ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН  
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН  
ТУШААЛ

2021 оны 09 сарын 20 өдөр

Дугаар 6790

Улаанбаатар хот

Д.Наранцэцэгийг ажлаас чөлөөлж,  
тэтгэмж олгох тухай

Монгол Улсын Хөдөлмөрийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1.8, 38 дугаар зүйлийн 38.1.1, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1, Компанийн Хөдөлмөрийн дотоод журмын 4 дүгээр зүйлийн 4.23, Компанийн Захиргаа, Үйлдвэрчний эвлэлийн хорооны хооронд байгуулсан 2019-2020 онд мөрдөх Хамтын гэрээний 5 дугаар зүйлийн 5.14 дэх заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1. Өндөр насны тэтгэвэр тогтоолгох хүсэлт гаргасан Хяналт, аюулгүй ажиллагааны хэлтсийн хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуй хариуцсан байцаагч-инженер Данзанбалжирын Наранцэцэг /122296/-ийг 2021 оны 09 дүгээр сарын 22-ны өдрөөс үүрэгт ажлаас нь чөлөөлж, хөдөлмөрийн гэрээг цуцалсугай.

2. Д.Наранцэцэгт эрчим хүчний салбарт 28 жил ажилласны тэтгэмжийг эрчим хүчний салбарт ажилласан жил тутамд салбарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ /672000 төгрөг/-г 2 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээгээр тооцож 37 632 000 /гучин долоон сая зургаан зуун гучин хоёр мянга/ төгрөгийн нэг удаагийн тэтгэмжийг олгохыг Санхүү бүртгэлийн хэлтсийн дарга бөгөөд ерөнхий нягтлан бодогч /О.Ариунболд/-д зөвшөөрсүгэй.

3. Д.Наранцэцэгийн ажлыг хүлээлцүүлж, ээлжийн амралтын олговор суутгалыг тооцож, холбогдох тооцоог хийж дуусгахыг Хяналт, аюулгүй ажиллагааны хэлтсийн дарга /А.Амаржаргал/, Санхүү бүртгэлийн хэлтсийн дарга бөгөөд ерөнхий нягтлан бодогч /О.Ариунболд/ нарт үүрэг болгосугай.

4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, хүний нөөцийн хэлтсийн дарга /Б.Баттүшиг/-д үүрэг болгосугай.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



Р.ДАГДАН

e:\2021 он\ashigfalt-2\зхнх\тэтгэвэрт гаргах.docx

3170602908